



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/191

Номгон

Гамшгаас хамгаалах дадлага, сургууль т  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12/54 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний 6.1.7 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Баянхонгор аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний 6.1.7 дугаар заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Гамшгаас хамгаалах "Иж бүрэн сургууль"-ийг Баянбулаг, Жинст, "Команд штаб"-ын сургуулийг Шинэжинст, Бөмбөгөр сумдад, аймгийн Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах "Бэлэн байдлын үзлэг"-ийг Гурванбулаг, Баянцагаан сумдад тус тус зохион байгуулсугай.

2.Гамшгаас хамгаалах дадлага, сургууль, аймгийн Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, хуваарийг хоёрдугаар, шаардагдах зардлыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Гамшгаас хамгаалах дадлага, сургууль аймгийн Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгт шаардагдах 5,753,280 (Таван сая долоон зуун тавин гурван мянга хоёр зуун наян/ төгрөгийг аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (С.Байгалмаа)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (хурандаа Ж.Алтангэрэл) т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

842310475

129  
Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр  
сарын 10-ны өдрийн 119/1 дүгээр  
захирамжийн дүгээр хавсралт




## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч Гишүүд	1.	Б.Мягмарсүрэн	Онцгой байдлын газрын орлогч, Урьдчилан сэргийлэх тасгийн дарга, дэд хурандаа;
	2.	М.Төмөрчөдөр	Гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахлах дэслэгч;
	3.	Д.Энхсайхан	Онцгой байдлын газрын Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн, ахлах дэслэгч;
	4.	Г.Лхагвасүрэн	Онцгой байдлын газрын ГТУАврах 16 дугаар ангийн Салааны захирагч, дэслэгч
	5.	Ж.Өлзийжаргал	Мал эмнэлгийн газрын Зооноз халдварт өвчин хариуцсан мэргэжилтэн;
	6.	Н.Наранхатан	Зоонозын өвчин судлалын төвийн Нян судлагч эмч;
	7.	Б.Шижээвандан	Онцгой байдлын газрын Эрэн хайх, аврах бүлгийн Аврагч, жолооч-холбоочин, ахлах ахлагч;
Нарийн бичиг	8.	Г.Баярсайхан	Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлтгэл бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, хошууч.

-----oOo-----

Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 1719/А дүгээр захирамжийн 2 дугаар хавсралт




**ГАМШГААС ХАМГААЛАХ СУРГУУЛЬ ДАДЛАГА,  
БЭЛЭН БАЙДЛЫН ҮЗЛЭГ ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ХУВААРЬ**

Д/д	Сургууль дадлага, бэлэн байдлын үзлэг зохион байгуулагдах сум	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага
1	2	3	4	5
<b>Гамшгаас хамгаалах "Иж бүрэн сургууль"</b>				
1.	Жинст	2023.04 сар	Онцгой байдлын газар	Мал эмнэлгийн газар, Зоонозын өвчин судлалын төв
2.	Баянбулаг	2023.09 сар	Онцгой байдлын газар	Мал эмнэлгийн газар, Зоонозын өвчин судлалын төв
<b>Гамшгаас хамгаалах "Команд штаб"-ын сургууль</b>				
3.	Шинэжинст	2022.04 сар	Онцгой байдлын газар	Мал эмнэлгийн газар, Зоонозын өвчин судлалын төв
4.	Бөмбөгөр	2023.09 сар	Онцгой байдлын газар	Мал эмнэлгийн газар, Зоонозын өвчин судлалын төв
<b>Аймгийн Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах "Бэлэн байдлын үзлэг"</b>				
5.	Баянцагаан	2023.04 сар	Онцгой байдлын газар	Мал эмнэлгийн газар, Зоонозын өвчин судлалын төв
6.	Гурванбулаг	2023.09 сар	Онцгой байдлын газар	Мал эмнэлгийн газар, Зоонозын өвчин судлалын төв

-----oOo-----

Аймгийн Засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн  
 № 191 дүгээр захирамжийн 3 дугаар хавсралт



**ГАМШГААС ХАМГААЛАХ СУРГУУЛЬ ДАДЛАГАД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

**А. ШАТАХУУН**

Д/д	Сумын нэр	Зохион байгуулах хугацаа	Автомашин	Нийт явах зам (км)	Шатахууны норм (дизель)	Зарцуулах шатахуун (л)	Шатахууны үнэ /төгрөг/	Нийт
1.	Жинст	04, 09 сар	Ланд Крузер-78	120	20	20	4140	82,800
2.	Шинэжинст			220	20	40	4140	165,600
3.	Баянцагаан			80	20	18	4140	74,520
4.	Баянхонгор			260	20	45	4140	186,300
5.	Бөмбөгөр			120	20	24	4140	99,360
6.	Баянбулаг			190	20	38	4140	157,320
7.	Гурванбулаг			90	20	19	4140	78,660
8.	Баянхонгор			270	20	48	4140	198,720
9.	<b>Нийт</b>			<b>1350</b>	<b>20</b>	<b>252</b>	<b>4140</b>	<b>1,043,280</b>

**Б. СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН МАТЕРИАЛ**

Д/д	Нэр		Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд
1	2		3	4	5
1.	Гамшгийн 10 төрөл бүр дээрх мэдээллийн самбар		10	90,000	720,000
2.	Гал унтраагуур		30	80,000	2,400,000
3.	Анонас (сургууль, дадлагын)		3	150,000	450,000
4.	Урьдчилан сэргийлэх ажлын зардал	Принтерийн хор	5	96,000	480,000
5.		Бичгийн цаас	18	20,000	360,000
6.		Фото цаас	10	30,000	300,000
7.	<b>Нийт</b>				<b>4,710,000</b>

**В. НЭГДСЭН ЗАРДЛЫН ТООЦОО**

Д/д	Нэр	Нийт зардал
1.	Шатахуун	1,043,280
2.	Сургалтын хэрэглэгдэхүүн, урьдчилан сэргийлэх ажлын материал	4,710,000
3.	<b>Нийт дүн</b>	<b>5,753,280</b>